

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021.06.14

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Өндөр кальциттай жоншны хүдрийн баяжигдах шинж чанарын битүү циклийн туршилт, судалгааны ажил хийх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын эзэмшилд буй жоншны ордуудын кальцитын өндөр агуулга бүхий жоншны хүдрийг флотацийн аргаар баяжуулж, өндөр чанарын баяжмал үйлдвэрлэх боломжтой урвалжын нэр төрлийг тодорхойлох, технологийн горимыг оновчлох, түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилготой.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээ /хуулбарыг ирүүлэх бол нотариатаар баталгаажуулна/
 - Байгууллагын санхүүгийн чадавхын мэдээлэл /сүүлийн 2 жилийн буюу 2018, 2019 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх/,
 - Татвар, нийгмийн даатгалын газар, Шүүхийн шийдвэр гаргах ерөнхий газар/ШШГЕГ/-ын тодорхойлолт зэргийг ирүүлнэ.
 - Сүүлийн 2 жилд кальцитын өндөр агуулгатай жоншны хүдрийг баяжуулах туршилт-судалгааг гүйцэтгэж, байсан туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, тайлангийн хамт ирүүлнэ.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө ажлын өдрийн 09-16 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 06 дугаар сарын 23 – ны өдрийн 10 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот-51, ш/х-002
Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо,
“Монголросцветмет” ТӨҮГ-ын өөрийн байр, өрөө: 305
И-майл: mailbox@monros.mn
Утас: 450060-138